

Гэлэгдоржийн Эрэгзэн[✉]

¹Шинжлэх ухааны Академийн Археологийн хүрээлэн,
Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайвны өргөн чөлөө,
Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр

Хүннүгийн язгууртны булшны холбогдох он цаг ба хувьсал хөгжлийн асуудал

Товчлол. Хүннүгийн язгууртны том булшийг Оросын эрдэмтэн П.К.Козловын экспедиц Монголын Ноён уулын дурсгалт газарт анх малтан судласнаас хойш 100 жил өнгөрсөн бөгөөд энэ бүх үеийн туршид Хүннүгийн язгууртан дээд давхаргад холбогдох том булштай 14 дурсгалт газраас Бор булгийн ам, Хялгант, Овооно хар зэрэг 3 газарт малтлага судалгаа хийгдээгүй, бусад 11 газарт судалгаа шинжилгээний ажил хийгдсэн байна. Одоогоор нийт 28 язгууртны том булшны малтлага судалгааг Монгол болон Өвөр Байгал, Тувагийн нутагт хийжээ. Мөн Дуурлиг нарс, Гол мод-II, Ямаан ус зэрэг 3 газарт судалгааны ажил ид хийгдэж байгаа юм.

Тус өгүүлэлд өнөөг хүртэл малтлага судалгаа хийсэн Хүннүгийн язгууртны булшны хэрэглэгдэхүүнийг хамруулан булшны илэрсэн үйлдвэрлэсэн цаг хугацааг илтгэх бичээст олдвор, харьцуулсан судалгааны үндсэн дээр холбогдох цаг хугацааг тодорхойлох боломжтой хүрэл толь, дүрс үсэг бүхий торго нэхмэл зэрэг олдвор хэрэглэгдэхүүн болон дээжийн радио-карбон задлан шинжилгээний үр дүнд тулгуурлан булшны **холбогдох он цагийг** тогтоож, түүнд үндэслэн Хүннүгийн үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн том хэмжээт язгууртны булшнууд бий болсон цаг хугацаа, нөхцөл байдлын талаар авч үзэв. Мөн шинээр малтлага судалгаа хийсэн Чихэртийн зоо дурсгалын хэрэглэгдэхүүнд тулгуурлан Хүннүгийн язгууртан дээд давхаргынханд холбогдох том хэмжээт булшны хувьсал өөрчлөлтийн асуудлыг хөндөхийг зорьсон юм.

Түлхүүр үг. Хүннү, язгууртны булш, том хэмжээт булш, үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн булш

Eregzen Gelegdorj[✉]

¹Institute of Archaeology,
Mongolian Academy of Sciences Building-1,
Peace avenue, Ulaanbaatar-13330, Mongolia

Chronological and evolutionary challenges associated with the Xiongnu aristocratic tombs

Abstract. It has been a century since the expedition led by Russian scholar P.K. Kozlov first investigated the large tombs of the Xiongnu aristocratic at the Noyon Uul monument in Mongolia. Throughout this period, excavations have not been conducted at three of the fourteen sites associated with the large tombs of the Xiongnu aristocratic, namely at Bor Bulgiin am, Hyalgant, and Ovoono Khar, while comprehensive archaeological investigations have been carried out at the other eleven. Currently, archeological excavation and research on a total of 29 large tombs of the aristocratic have been conducted in Mongolia, ZaBaikal, and Tuva. Additionally, ongoing research activities are being conducted at three sites: Duurlig Nars, Gol Mod-II, and Yamaan Us. This article includes the use of items from the excavated tombs of the Xiongnu aristocratic up to the present, encompassing artifacts that illustrate the manufacturing dates derived from the tombs, bronze mirrors, and engraved silk, which help determine related time periods based on comparative studies, and results of radiocarbon dating of samples that establish the chronological context for the tombs. Based on these findings, the article discusses the time period and conditions in which the large square-shaped tombs characteristic of the Xiongnu nobility were established. Based on this foundation, the article discusses the time period and conditions in which the large square-shaped tombs characteristic of the Xiongnu elite were established. Additionally, based on the artifacts from the newly investigated Chikhertiin Zoo memorial site, this research addresses the issues of transformation and change in the large tombs associated with the Xiongnu's upper echelons. It examines how the tombs evolved from circular to square shapes, and suggests that, based on the accumulated artifacts, it is possible to divide their development into three stages.

Keywords. Xiongnu, aristocratic tomb, large tomb, large square-shaped tomb with gate

Оршил

Өнгөрсөн 100 гаруй жилийн хугацаанд Хүннү нарт холбогдох хот суурины үлдэгдэл, булш оршуулга, хадны сүг зураг зэрэг археологийн дурсгалууд олон газраас илэрч судлагдан тэдний ахуй амьдралын талаар ихээхэн мэдээллийг өгсөн. Тэр дундаа булш оршуулгаас олдсон олдворууд нь Хүннүгийн эдийн соёлыг судлахад чухал ач холбогдолтой хэрэглэгдэхүүнд тооцогдож байна.

Одоогийн байдлаар Монгол улсын нутаг болон ОХУ-ын Буриадын БНУ, Тувагийн БНУ, БНХАУ-ын Өвөр Монголын ӨЗО, Шинжан-уйгарын ӨЗО, Хөхнуур муж зэрэг өргөн уудам нутгаас Хүннү нарт холбогдох 15 мянга гаруй булш оршуулгын дурсгал илэрч мэдэгдээд байна. Эдгээр булшнууд нь ерөнхийдөө үүдэвчтэй дөрвөлжин болон цагариг хэлбэрийн гадаад чулуун байгууламжтай бөгөөд эхнийхийг язгууртан дээд давхаргыханд, удаахийг “жирийн иргэд” болон орон нутгийн ноёдын оршуулга хэмээн үзэж тайлбарлаж хэвшчээ. Язгууртны булшнууд нь хэмжээний хувьд харьцангуй том, газрын хөрсөн дээр ил товойн харагдах шороон овоолготой, түүний захаар чулуу өрж хашсан дөрвөлжин хэлбэрийн байгууламжтай, өмнө талдаа трапец хэлбэрийн урт үүдэвчтэй байдгаар цагариг хэлбэрийн жирийн жижиг булшнуудаас эрс ялгардаг.

Язгууртан дээд давхаргынханд холбогдох том хэмжээтэй булш бүхий Ноён уул, Гол мод, Гол мод-II, Дуурлиг нарс, Бор булгийн ам, Тахилтын хотгор, Бэлхийн ам, Хялгант, Овооно хар, Ямаан ус зэрэг 10 оршуулгын газар Монгол улсын нутагт оршин байна. Харин Ильмийн ам (Сүүж), Царам, Оргойтон зэрэг язгууртны булш бүхий 3 дурсгал Буриадын БНУ-ын нутаг Өвөр Байгалаас, Бай Даг-II хэмээх язгууртны булштай газар Тувагийн БНУ-ын нутгаас илэрч судлагджээ¹.

Дээрх 14 оршуулгын газарт байгаа язгууртны булшны тоо харилцан адилгүй юм. Тухайлбал, Ноён уулын дурсгалт газарт нийт 300 булш бүртгэснээс 78 орчим [Эрдэнэ-Очир нар, 2021, зураг 1.7-10], Гол модны дурсгалт газарт 418 булш бүртгэснээс 180 орчим [Ерөөл-Эрдэнэ, 2015, 42], Гол мод-II дурсгалт газарт 400 гаруй булш байгаагаас 100 орчим [Эрдэнэбаатар нар, 2021, 29], Дуурлиг нарсны дурсгалт газарт 299 булш бүртгэснээс 80 орчим [Эрэгзэн нар, 2011, 35], Бор булгийн аманд 140 гаруй булш байгаагаас 50 орчим [A report ... ‘Gurvan gol’ 1994, 7], Тахилтын хотгорт

1 Нэр дурдсан дурсгалт газруудаас гадна сүүлийн жилүүдэд хийгдэж буйхайгуулсудалгааны үрдүнд үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн гадаад чулуун байгууламжтай булшнууд хэд хэдэн дурсгалт газар илэрсэн бөгөөд эдгээр нь цагариг хэлбэрийн булшнуудтай нэг дор байрлах төдийгүй хэмжээний хувьд харьцангуй жижиг байна. Тиймээс шууд язгууртны булш хэмээн үзэх боломжтой эсэх зэрэг олон асуудлууд урган гарч буй бөгөөд одоогоор малтлага судалгаа хийгдээгүй, цаашид нэмэлт судалгаа шаардлагатай тул энд оруулалгүй орхисон болно.

140 гаруй булш байгаагийн 30 орчим [Баярсайхан, Эгиймаа 2008, 1-р зураг], Бэлхийн аманд 10 булш байгаагийн 6 нь үүдэвчтэй дөрвөлжин хэлбэртэй язгууртны булш [Эрэгзэн нар, 2022, 9]-нууд байна². Харин Ильмийн аманд байх 300 гаруй булшны 14 [Konovalov, 2008, Pl 2], Царамд буй 20 булшны 5 [Miniaev, Sakharovskaia 2007], Оройтонд байх 14 булшны 4 [Коновалов, 1976, 23], Тувагийн Бай Даг-2 дурсгалт газарт байгаа 16 булшны 5 [Николаев, 2003, 260] нь язгууртны үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн булш болох нь мэдэгдэнэ. Эндээс үзвэл одоогоор тодорхой мэдэгдэж байгаа Хүннүгийн 15 мянга гаруй булшнаас 600 гаруй буюу 25/1 орчим нь язгууртны булш болж байна. Өөр нэг сониролтой статистик үзүүлэлт нь нийт олдсон язгууртны булшны 96 орчим хувь нь Монгол улсын нутагт, үлдэх 4 хүрэхгүй хувь нь ОХУ-ын нутагт байх бөгөөд Ильмын ам, Царам, Оройтон, Бай Даг-II зэрэг дурсгалууд бүгд Монголтой хиллэх хилийн бүсэд байрлана.

Хүннүгийн язгууртны булшийг анх Ноён уулын дурсгалт газарт П.К.Козловын удирдсан шинжилгээний анги 1924 онд малтан шинжилснээс хойш зуу орчим жилийн хугацаанд дээрх 14 дурсгалт газраас Бор булгийн ам, Хялгант, Овооно хар зэрэг 3 газарт судалгаа хийгдээгүй, харин бусад 11 газарт язгууртны булшны малтлага судалгааны ажил хийгдэж, нийт 39 булшийг малтан шинжилсэн байна. Одоогийн байдлаар Дуурлиг нарс болон Гол мод-II, Ямаан ус [Эрэгзэн, нар 2022; Эрдэнэбаатар нар, 2021; Хатанбаатар нар, 2023] зэрэг дурсгалт газарт язгууртны булшны малтлага судалгааны ажил үргэлжилж байна.

Тус өгүүлэлд сүүлийн үеийн судалгааны үр дүнд тулгуурлан Хүннүгийн язгууртны булшны холбогдох он цагийн талаар авч үзэхийн зэрэгцээ үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн булш бий болсон цаг хугацаа, ийм хэлбэрийн булш байгуулах болсон нөхцөл байдал, Хүннүгийн язгууртны булшны хувьсал хөгжлийн үйл явцын талаарх зохиогчийн таамаглалыг танилцуулахыг зорив.

Хүннүгийн язгууртны булшны холбогдох он цаг

Хүннүгийн язгууртны булшны холбогдох он цагийг тогтооход ерөнхийдөө 2 төрлийн аргыг ашигладаг. Энэ нь нэгт үйлдсэн газар, хийсэн хүн болон цаг хугацааны тухай мэдээлэл агуулсан бичээс, зураг дүрслэл бүхий өмнө зүгийн гаралтай чий будагтай эдлэл, хүрэл толь, ханз үсэгтэй

2 Дээрх оршуулгын газруудад буй язгууртны булшийг нарийн тоолсон бүртгэл байхгүй тул дурьдсан бүтээлүүдэд хэвлэгдсэн дурсгалт газрын дэвсгэр зургийн тэмдэглэгээг тоолох байдлаар гаргав. Түүнээс гадна зарим дурсгалт газруудын дэвсгэр зураг хэвлэгдээгүй, мөн судалгаа хийсэн судлаачид нийт хэдэн булштайгаас хэд нь үүдэвчтэй дөрвөлжин хэлбэртэй талаар нарийвчлан тоолж бүртгээгүй тул тоймлон үзэв.

торго нэхмэл зэрэг олдворын харьцангуй он цагт тулгуурлах арга, хоёрт булшнаас илэрсэн органик эдийн дээжийг тусгай лабораторид илгээн цацраг идэвхит нүүрсхүчлийн изотопын хэмжээг тоолох радио-карбон шинжилгээний үр дүнд тулгуурлан тухайн олдворын үнэмлэхүй он цагийг тогтоох арга юм. Дор өнөөг хүртлэх хугацаанд дурсгалын он цагийг тогтооход ашиглаж байсан харьцангуй он цагийн хэрэглэгдэхүүн болох чий будагтай аяга, хүрэл толь, торго нэхмэл зэрэг өмнө зүгийн гаралтай эдлэлүүдийн он цагийн мэдээлэл болон булшнаас авсан дээжийн радио-карбон шинжилгээний үр дүнг тусгайлан авч үзье.

Монгол болон ОХУ-ын Өвөр Байгалд малтлага судалгаа хийсэн Хүннүгийн язгууртны булшнаас үйлдсэн газар, хийсэн хүн болон цаг хугацааны тухай мэдээлэл агуулсан бичээс бүхий өмнө зүгийн гаралтай чий будагтай эдлэл, мөн дүрслэл, хийц зэргийг харьцуулан үйлдвэрлэгдсэн цаг хугацааг тогтоох боломжтой хүрэл толь, ханз үсэгтэй торго нэхмэл зэрэг булшийг бүтээсэн он цагийг баримжаалахад чухал хэрэгтэй олдвор эд өлгийн зүйлс цөөнгүй олдсон байдаг.

Чий будагтай эдлэлийн хувьд дийлэнх булшнаас илэрсэн боловч үйлдвэрлэсэн газар, хийсэн цаг хугацааг мэдэх боломжтой бичээсийг уншиж тодруулсан олдвор харьцангуй цөөн байна. Эдгээрээс Ноён уулын 6-р булшнаас олдсон аяганы бичээс, Симуковын малтсан булшнаас илэрсэн аяганы бичээсүүдийг онцлон дурдах хэрэгтэй. Ноён уулын 6-р булшнаас илэрсэн аяга нь амсарын 2 талд чих маягийн бариултай, ёроолдоо “上林” гэсэн 2 ханз үсгийг нарийн үзүүртэй зүйлээр сийлсэн агаад ёроолын гадна талын хүрээг дагуулан бичсэн “建平五年九月 工王 潭經 畫 工獲壺 天武省” ийм 17 үсэг бүхий бичээстэй чий будагтай модон аяга илэрсэн байдаг. Энэ дурсгалт газарт Симуковын малтсан булшнаас “建平五年 蜀郡西工.....” гэсэн 67 үсэг бүхий бичээстэй чий будагтай аяга олджээ. Бичээснээс үзвэл 2 аягыг хоёуланг нь Цяньпингийн 5-р он (НТӨ 2 он)-д үйлдсэн нь мэдэгдэнэ. Н.В.Бернштам бичээсийг баримтлан 6-р булшнаас илэрсэн аягыг Үжүлюжоди шаньюйг Хан улсын хааны Шанлиньюан ордонд айлчлахад бэлэг болгосон зүйл хэмээн тайлбарлаад уг булшийг НТ 13 онд нас нөхчсөн тэрхүү шаньюйн булш хэмээн үзсэн байдаг [Бернштам, 1951, 37]. Харин Ц.Доржсүрэн бусад эдийн боловсролын зүйлсийг харгалзан үзээд 6-р булшийг НТӨ I зуунаас НТ I зуунд холбогдоно хэмээн тайлбарлажээ [Доржсүрэн, 1961, 59-62]. 2006 онд малтлага хийсэн Ноён уулын 20-р булшнаас 3 ш чий будагтай аяга олдсоны 1 аяганы ёроолд 46 үсэг бүхий бичээс байв. Уг бичээсэн дундах “元延四年” гэсэн 4 үсэг нь аягыг НТӨ 9 онд үйлдсэнийг тодорхой хэлж өгч буй юм

[Chistyakova, 2009, 65]. Эдгээр хэрэглэгдэхүүн нь дээрх 3 булшийг НТӨ 9 он болон НТӨ 2 оноос эрт байгуулаагүйг баталж байна.

Гол модны 20-р булшнаас илэрсэн чий будагтай модон тавагны ёроолд 30 ханз үсэг мэдэгдэх бөгөөд түүнд тулгуурлан уг тавгийг НТӨ 16 онд бүтээснийг тогтоосон байна [Ерөөл-Эрдэнэ, 2015, 118]. Царамын дурсгалт газрын 7-р булшнаас илэрсэн чий будагтай аяган дээрх бичээсийг тайлж уншсан судлаачид аягыг НТӨ 8-НТ 4 оны үед холбогдоно хэмээн үзсэн байдаг [Миняев, Сахаровская 2007, 54].

Ноён уулын 1-р, 6-р зэрэг хэд хэдэн булшнаас “新神靈廣成壽萬年” ханз үсэгтэй торгоны үлдэгдэл олджээ. Энэ торго нь Баруун Хан улсын төгсгөлд төрийн эргэлт хийж Шин хэмээх улс байгуулан охорхон хугацаанд хятадыг захирсан Ван Маны үед холбогдоно [Umehara, 1960; Руденко 1962].

Ноён уулын 22-р, 25-р булш, Гол модны 1-р, 20-р булш, Дуурлиг нарсны 2-р булш, Царамын 7-р булш, Гол мод-2 дурсгалын 189-р булшнаас хүрэл толины хагархай олджээ. Дээрх дүрслэлээс үзвэл Гол модны 20-р болон Дуурлиг нарсны 2-р булшнаас илэрсэн толь нь судлаачдын дунд “ТЛВ (TLV規矩鏡)” хэлбэрийн хэмээн алдаршсан хүрэл толь, Ноён уулын 22-р булшнаас олдсон толь нь “дөрвөн товч, дөрвөн угалзат”, Ноён уулын 25-р, Царамын 7-р булшнаас олдсон нь “дөрвөн товч, дөрвөн амьтант (四乳四神鏡)”, Гол модны 1-р, Гол мод-2 дурсгалын 189-р булшнаас гарсан нь “үүл, цахилгаант (雲雷連弧文鏡)” толины хагархай болох нь төвөггүй танигдана. Хан хийцийн хүрэл толины судалгаанд тулгуурлавал, “ТЛВ” хэлбэрийн толь нь дээрх дүрслэлээс шалтгаалан “四神規矩鏡, 鳥獸規矩鏡, 幾何文規矩鏡, 簡化規矩鏡” гэх мэтээр ангилагдах [孔祥星, 劉一曼 2003, 156-170] бөгөөд Дуурлиг нарсны 2-р болон Гол модны 20-р булшнаас олдсон толины хагархай нь “Жигүүртний дүрст ТЛВ (鳥獸規矩鏡)” ангилалд багтах боломжтой байна. “Жигүүртний дүрст ТЛВ” толь нь Зүүн Хан улсын эхэн, дунд үед холбогдоно. Харин Ноён уулын 22-р булшнаас илэрсэн “дөрвөн товч, дөрвөн угалзат”, Ноён уулын 25-р болон Царамын 7-р булшнаас олдсонтой ижил “дөрвөн товч, дөрвөн амьтант” толинууд нь Баруун Хангийн төгсгөл, Зүүн Хангийн эхэн үед холбогддог байна [Эрэгзэн, 2009, 185]. Гол модны 1-р булшнаас олдсон “үүл, цахилгаант” толийг Францын судлаачид хятадын хэрэглэгдэхүүнтэй харьцуулан НТ I зууны дунд үед холбогдоно хэмээн үзжээ [Le preimer, 2003: 257]. Эндээс үзвэл хүрэл толь илэрсэн булшнууд ч мөн адил НТ I зуунд холбогдох боломжтой байна. Сүүлийн жилүүдэд Хүннүгийн язгууртны булшнаас илэрсэн мод, яс зэрэг органик эдээс дээж

1-р хүснэгт. Хүннүгийн язгууртны булинаас олдсон он цаг тогтоох хэрэглэгдэхүүн

	Булшны дугаар	Чий будагтай эдлэл	Хүрэл толь	Торго нэхмэл	Радио-карбон задлан шинжилгээ	Холбогдох он цаг
1	Ноён уул 6-р булш	НТӨ 2 он		НТ I зууны эхэн хагас	НТӨ 2-НТ 232	НТ I зуун
2	Ноён уул, Симуковын булш	НТӨ 2 он				НТ I зуун
3	Ноён уул, 25-р булш		НТӨ I-НТ I зуун (дөрвөн амьтан)			НТ I зуун
4	Ноён уул, 1-р булш			НТ I зууны эхэн хагас		
5	Ноён уул, Доржсүрэнгийн малтсан 1-р булш					
6	Ноён уул, 20-р булш	НТӨ 9 он				НТ I зуун
7	Ноён уул, 31-р булш	НТӨ 9 он				
	Ноён уул, 22-р		НТӨ I-НТ I зуун (дөрвөн угалз)			НТ I зуун
8	Ноён уул, 11-р булш				НТӨ 2-НТ 84 НТӨ 39-НТ 78	НТ I зуун
9	Гол мод, 1-р булш		НТ I зуун (үүл, цахилгаант)		НТӨ 114-НТ 258	НТ I зуун
10	Гол мод, 20-р булш	НТӨ 16 он	НТ I зуун (ТЛВ)		НТӨ 169-НТ 31	НТ I зуун
11	Гол мод, 79-р булш				НТ 21-170	НТ I зуун
12	Дуурлиг нарс, 2-р булш		НТ I зуун (ТЛВ)		НТӨ 110-НТ 230 НТӨ 210-НТ 80 НТӨ 100-НТ 230	НТ I зуун
13	Дуурлиг нарс, 1-р булш				НТӨ 40-НТ 80 НТӨ 60-НТ 90	НТ I зуун
14	Гол мод-2, 1-р булш				НТӨ 186-НТ 3	НТ I зуун
15	Гол мод-2, 189-р булш		НТ I зуун (үүл, цахилгаант)		НТӨ 49-НТ 72	НТ I зуун
16	Бэлхийн ам, 3-р булш				НТӨ 103-НТ 26 НТ 61-НТ 210	НТ I зуун
17	Тахилтын хотгор, 64-р булш				НТӨ 42-НТ 65	НТ I зуун
18	Ильмын ам, 54-р булш				НТӨ 56-НТ 92	НТ I зуун
19	Царам, 7-р булш	НТӨ 8-НТ 4 он	НТӨ I-НТ I зуун (дөрвөн амьтан)		НТ 30-120	НТ I зуун

авч радио-карбоны аргаар он цаг тогтоох судалгааг харьцангуй сайн хийж байна. Тухайлбал, Дуурлиг нарс, Гол мод, Гол мод-II, Ноён уул, Тахилтын хотгор, Ильмийн ам, Царам зэрэг олон дурсгалт газарт малтлага хийсэн язгууртны булшнууд болон тэдгээрийн дагуул булшнаас дээж авч радио-карбон шинжилгээ хийсэн. 2015 онд Ч.Ерөөл-Эрдэнэ нийт 32 булшнаас авсан радио карбоны үр дүнг нэгтгэн хэвлүүлсэн бөгөөд тэдгээрийн он цаг дийлэнх нь НТӨ I зуунаас НТ I зуунд холбогдохоор гарсан байна [Ерөөл-Эрдэнэ, 2015, 122]³.

Ийнхүү бүтээгдсэн цаг хугацаа тодорхой мэдэгдэж буй Хан хийцийн чий будагтай эдлэл, хүрэл толь болон мод, ясны дээжийн радио-карбоны задлан шинжилгээний үр дүнгүүд ерөнхийдөө давхцаж буй нь Монгол болон Өвөр Байгалд тархсан Хүннүгийн язгууртны булшнуудын дийлэнх НТ I зууны үед бүтээгдсэн хэмээн үзэх боломжийг олгож байгаа юм.

Булшны үнэмлэхүй он цагийг тогтоож буй радио-карбоны шинжилгээний үр дүн хэдийгээр хамгийн бодитой боловч тухайн дээжийг хэрхэн бэлтгэж авсан, гадны нөлөөлөл орсон эсэх, дээжид сонгож авсан органик зүйлийн өөрийн насжилт гэх мэт олон хүчин зүйлээс шалтгаалан хэлбэлзэл, савлагаа өндөртэй байдаг. Тиймээс шууд хүлээн зөвшөөрөхөөс өмнө харьцуулан үзэж баталгаажуулах шаардлага бий. Энд хүснэгтэд хамт олдсон харьцангуй он цагийг тогтоох боломжтой олдворуудыг хамт жагсаасан нь дурсгалын он цагийг илүү нарийвчилсан байдлаар тогтооход нэмэртэй хэмээн үзснийх билээ.

Харьцуулсан судалгаагаар насыг тогтоох боломжтой олдворууд дотроос чий будагтай эдлэлүүд нь үйлдвэрлэсэн цаг хугацааны талаарх бичээстэй тул хамгийн тодорхой байна. Гэхдээ уг олдвор булш бүтээсэн цаг хугацааг шууд заахгүй гэдгийг давхар бодолцох учиртай. Өөрөөр хэлбэл, чий будагтай эдлэлийг бүтээсэн он гэдэг бол тухайн олдвор илэрсэн булшны он цаг түүнээс өмнөх цагт холбогдохгүй гэдгийг л зааж байгаа юм. Жишээлбэл, Ноён уулын 6-р булшнаас илэрсэн чий будагтай аягыг НТӨ 2-р онд хийсэн нь тодорхой бөгөөд энэ нь уг булшийг түүнээс хойш бүтээснийг харуулна. Энэ булшнаас Ван Маны байгуулсан Шин улсын үед дэлгэрч байсан хятад бичээстэй торго олдсон бөгөөд тэрхүү олдвор нь булшийг НТ I зууны 10-аад оноос хойш бүтээгдсэнийг илүү тодруулж өгч байна.

Хүрэл толины хувьд үйлдвэрлэсэн цаг хугацааг нарийн тодорхойлох боломжгүй эд

3 Ч.Ерөөл-Эрдэнийн нийтлэсэн 32 булшны радио-карбон шинжилгээний үр дүн нь язгууртны булш болон дагуул булшнаас авсан дээжүүдийг нэгтгэсэн авч үзжээ. Зохиогч тус өгүүлэлд зөвхөн язгууртны булшнаас авсан дээжийн радио-карбон шинжилгээний үр дүнг оруулсан бөгөөд сүүлийн үед гарсан шинэ үр дүнгээр баяжуулсан болно.

хэдий ч хээ чимэглэл нь тодорхой цаг үеэс эхлэн дэлгэрч байсныг харьцуулан тогтоосон байдаг тул дурсгалын он цагийг баримжаалахад түлхүү ашигладаг олдворын нэг юм. Ноён уул, Царам зэрэг төвийн бүс нутагт малтлага хийсэн язгууртны булшнуудаас ихэвчлэн “дөрвөн товч, дөрвөн угалзаг” болон “дөрвөн товч, дөрвөн амьтан”-ы дүрстэй Баруун Хан улсын төгсгөлд дэлгэрсэн хүрэл толины төрлүүд илэрсэн бол Гол мод, Гол мод-2, Дуурлиг нарс зэрэг дурсгалт газруудаас “ТЛВ” болон “үүл, цахилгаан” төрлийн хүрэл толинууд олджээ. “ТЛВ” болон “үүл, цахилгаан” төрлийн хүрэл толины хувьд Зүүн Хан улсын үед дэлгэрч байв. Ялангуяа “үүл, цахилгаан” төрлийн хүрэл толинууд НТ I зууны 2-р хагасаас хүчтэй дэлгэрч эхэлсэн байдаг [孔祥星, 劉一曼, 2003, 218]. Эндээс үзэхэд Хүннүгийн язгууртны булшнууд нь нийтдээ НТ I зуунд бүтээгдсэн хэдий ч үнэмлэхүй болон харьцангуй он цагийн хэрэглэгдэхүүнийг харьцуулан үзвэл Гол мод, Гол мод-2, Дуурлиг нарс зэрэг дурсгалууд нь Ноён уулын дурсгалаас илүү хожуу үед холбогдох магадлал өндөр байна. Энэхүү он цагийн ялгаатай байдал дурсгалын байршил, газар (хөрс) сонголт, булшны дотоод бүтэц, зохион байгуулалтын онцлог зэрэгт ч ажиглагдаж байна. Энэ талаар хойно дахин өгүүлье.

Үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн Хүннүгийн язгууртны булш бий болсон нөхцөл

Тус өгүүлэлд дурдан буй Хүннүгийн язгууртны булш гэдэг нэр томъёо нь газрын өнгөн хөрсөн дээр үүдэвч бүхий дөрвөлжин хэлбэрийн хүрээлсэн чулуун байгууламжтай, газрын гүнд шатлан багасгаж ухсан нүхтэй, ёроолд нь дан болон давхар модон хашлага дотор модон авсанд хүнээ оруулсан оршуулгын байгууламжийг авч үзэж байна. Ийм хэв шинж хоорондоо хэдэн зуугаас хэдэн мянган км алслагдсан дурсгалт газруудад малтлага хийсэн булшнуудад нийтлэг ажиглагдаж байгаа юм. Тухайлбал, Дуурлиг нарсны дурсгал нь Монголын зүүн бүс нутагт байрлах бол Ноён уул, Бэлхийн амны дурсгал нь Монголын төвийн бүс нутагт Улаанбаатар хотын ойролцоо байрлана. Гол мод, Гол мод-II дурсгал нь мөн л Монголын төвийн бүсийн баруун хэсэгт Улаанбаатар хотоос баруун тийш 500 орчим км зайд байна. Харин Тахилтын хотгор, Овооно хар зэрэг дурсгалууд нь Монголын баруун бүс нутагт нийслэл хотоос 1000 гаруй км зайд байрлана. Тэгэхээр зүүн захын Дуурлиг нарснаас баруун захын Тахилтын хотгорын дурсгал хүртэл бараг 2000 км алслагдсан гэсэн үг. Ийм алс хол байрлах хэдий ч эдгээр дурсгалуудын гадаад хэлбэр болон дотоод бүтэц, дагалдуулсан эд өлгийн зүйлсэд нийтлэг байдал ажиглагдах

ба он цаг нь ч хоорондоо ойролцоо байна гэдэг нь Хүннүгийн үед язгууртнуудыг оршуулахад нэгдсэн хэлбэр, тогтсон ёс хэдий нь бий болсон байсныг харуулдаг.

Хятад сурвалжийн мэдээ баримтаас үзэхэд Хүннү гүрэн НТӨ III зууны төгсгөлөөс НТ I зууны төгсгөл хүртэл 300 илүү жил оршин тогтносон. Хүннү гүрэн эхний үед буюу Модун шаньюйгаас Гүнчен шаньюй хүртлэх 70 гаруй жилийн хугацаанд маш хүчирхэг байж өмнөд хөрш Хан улсаас алба татвар авч, одоогийн Шинжаны нутагт байсан баянбүрд дагасан хот улсуудыг хяналтандаа байлган дорно-өрнийг холбосон худалдааны замаас асар их ашиг олж байжээ. Түүний дараагаар Хан улсад У-ди хаан ширээнд сууснаас хойш өмнөд хөрштэйгээ 40 жил үргэлжилсэн дайн хийж хүч нь тарамдсан ба НТӨ I зууны дунд үед дотоодын хагарлаас болж ихээхэн суларчээ. Улмаар НТӨ 30-аад онд Хүннүгийн Хуханье шаньюй Хан улсаас тусламж авах хэмжээнд хүртэл доройтсон байдаг. Хан улсад бий болсон төрийн хямралыг далимдуулан Хүннү улс дахин хүчирхэгжиж ирсэн ч НТ I зууны 40-өөд оноос Умард, Өмнөд болон хуваагдаж бууралтын замдаа оржээ⁴.

Түүхэн сурвалжийн он тоололтой харьцуулан үзвэл бидний хэлэлцэж буй язгууртны булшнууд Хүннү гүрний дунд болон төгсгөл үед холбогдох нь тодорхой байна. Үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн язгууртны булшны нүхийг ухсан байдал зарим талаар Хятадын Хан улсын үе болон түүнээс өмнөх Цин улсын үеийн булшнуудтай төстэй байдал ажиглагддаг. Тиймээс судлаачид Хүннүгийн язгууртны булшинд Хан улсын соёлын нөлөө туссан хэмээн үздэг бөгөөд язгууртны булшнаас илэрдэг чий будагтай сав суулга, хүрэл толь, чий будагтай сүйх тэрэг зэрэг олон тооны хятад хийцийн олдворыг нотолгоо болгон авч үзсээр ирсэн. Гэхдээ булшны бүтэц зохион байгуулалтын онцлогийг нарийн ажиглахад үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн язгууртны булшны дотоод байгууламж буюу модон хашлагын хэлбэр, оршуулгын зан үйлийн ул мөр нь өмнөх үеийн уламжлалыг илүүтэй хадгалсан шинжтэй, булшны нүхийг ухсан арга барил, хэлбэр нь Хан улсын нөлөө туссан байдалтай ба гадаад байгууламж нь огт шинээр бий болсон зүйл болох нь мэдэгддэг [Эрэгзэн, 2010: 286-287]. Олдвор эд зүйлсийн хувьд ч дан Хятад зүйлс голлодог бус Дундад Ази, Грек-Бактри, Ром, Египетээс ирсэн харь гаралтай зүйлс, мөн өөрсдийн дотоодын бүтээгдэхүүн зэргийг хослуулсан олон талтай болох нь нэгэнт

⁴ Тус өгүүлэлд дурдан буй Хүннүгийн түүхийн талаарх мэдээ баримтууд нь Сыма Цяны “Түүхэн тэмдэглэл”, Бан гугийн “Хан улсын бичиг” зэрэг сурвалжаас шиллэл авсан зүйлс бөгөөд энэхүү түүхэн сурвалжийн талаарх Монгол болон Солонгос хэл дээрх орчуулгуудыг ашигласан. Эдгээрийг ном зүйн жагсаалтад оруулав.

тодорхой болжээ. Энэ байдал нь Хүннүгийн язгууртнууд тухайн цаг үедээ дэлхийн голлох улс гүрнүүдтэй өргөн харилцаатай, гадаадын дэвшилттэй зүйлсийг авч ашиглаж чаддаг, олон соёлын уулзвар дээр өөрсдийн соёлыг бий болгон хөгжүүлж байсныг харуулдаг.

Энд анхаарал татаж буй зүйл нь үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн асар том хэмжээтэй булшнууд яагаад Хүннү гүрний дунд болон төгсгөлийн шатанд бий болсон ба ийм булшнууд гарч ирэх болсон нөхцөл байдлын асуудал юм. Хөгжлийн зүй тогтол талаас үзвэл асар том хэмжээтэй булш хамгийн хүчирхэг байх цаг үед бүтээгдсэн байх учиртай. Үүний шалтгааныг тайлахад нэмэр болохуйц сурвалжийн зарим мэдээ баримт байна. Одоогоор малтлага судалгаа хийсэн Хүннүгийн язгууртны булшнууд дотор эрт цагт тонуулчид сүйтгээгүй булш бараг байхгүй⁵. Түүнээс гадна малтлага хийгээгүй булшнууд ч эрт цагт тоногдож сүйтгэгдсэн болох нь гадаад байдлаас мэдэгддэг.

“Хан улсын бичиг”-ийн “Хүннүгийн шастир” болох 94-р бүлэгт Хүннүгийн шаньюй нарын булшийг ухуаньчууд тонож сүйтгэсэн талаар дараах мэдээг тэмдэглэж үлдээжээ. Уг мэдээнд “ухуаньчууд тэнгэрт хальсан шаньюйн булш онгоныг ухаж тонож сүйтгэсэнд хүннүчүүд хилгэнэн 2 түмэн цэрэг илгээн ухуанийг довтлов” хэмээн бичсэн байна. Сурвалжийн мэдээ баримтыг тулган шүүж үзэхэд энэ үйл явдал Жаоди хааны Юаньфэний дөрөвдүгээр он буюу НТӨ 77 онд болсныг мэдэх боломжтой ажээ. Энэ үед Хүннүг Хуаньди шаньюй удирдаж байсан бөгөөд түүнд хятад зөвлөх Вэй Люй “худаг гаргаж, хэрэм байгуулан, барилга байшин босгож, үр тариагаа хадгалах ажлыг цин хүмүүс (хятадаас хүннүд даган орсон хүмүүс)-т хариуцуулья. Тэгвэл Хан улсын цэрэг довтлон ирсэн ч биднийг яаж ч чадахгүй” хэмээн зөвлөсөн бөгөөд түүний зөвлөсний дагуу “хэдэн зуун худаг ухаж, хэдэн мянган мод огтлов” гэж тэмдэглэсэн байна [Баруун Хан улсын бичиг. УБ., 2020, 242, 246; 漢書 外國傳 譯註 (上), 2009: 150, 153].

Зохиогч өмнө нь Төв аймгийн Баянжаргалан сумын нутагт байрлах Гуа довын дурсгалт газарт малтлага хийсэн судалгааны үр дүнд тулгуурлан Гуа дов болон Хэрлэнгийн баруун эрэг дагуу цувруулан байгуулсан язгууртны ордны үлдэгдэл болох 5 дурсгалыг Хуаньди шаньюйн төр барьсан цаг үе буюу НТӨ 85-65 оны хооронд байгуулсан байх боломжтой талаар таамаглал дэвшүүлж байсан. Ийнхүү таамаглал дэвшүүлэх болсон шалтгаан нь Гуа дов дурсгалын 5 Одоогоор малтлага хийсэн 39 язгууртны булшнаас Гол мод-2 дурсгалт газарт малтлага хийсэн 10-р булш л тоногдож сүйтгэгдээгүй илэрсэн бол үлдсэн бүх булш толгой дараалан тоногдож сүйтгэгдсэн байв.

радио-карбон шинжилгээний үр дүн болон уг дурсгалд холбогдох бөөгийн дуудлагад гарч буй нэр, газарзүйн байрлал, мөн олон мод огтлох боломжтой газар орон зэрэг олон хүчин зүйлийг харшуулан үзсэнтэй холбоотой юм [Эрэгзэн, 2018: 203-210].

Түүхэн нөхцөл байдлаас үзэхэд Хүннү болон Хан улсын хооронд үргэлжилсэн 40 жилийн урт дайн тулааны үр дүнд Хүннүгийн язгууртны орд говийн хойно гарч, түүнээс хойш говийн өмнө зүгийн нутагт хүннүчүүд харьцангуй цөөн суух болсон байдаг. Ухуаньчуудын хувьд Хүннүд татвар төлж захирагддаг байсан бөгөөд говийн хойно Хүннүгийн үндсэн хүч төвөрч байсан төдийгүй Хан улсаас сэргийлж хилийн бэхлэлт суурин байгуулж, хамгаалалтдаа их анхаарч байсан цаг үе тул ухуаньчууд шууд говийн хойно гарч нутгийн гүнд нэвтрэх боломж бага харагддаг. Харин говийн өмнө талын нутаг буюу одоогийн Өвөр Монголын нутагт хүннүгийн хараа хяналт суларсан байдлыг ашиглан ухуаньчууд тэнгэрт хальсан шаньюй нарын булшийг ухаж сүйтгэх боломжтой байжээ хэмээн үзэж болох юм. Хэрэв тийм бол эрт үеийн Хүннүгийн шаньюй нарын булш говийн өмнө буюу Өвөр Монголын нутагт байх боломжтой бөгөөд ухуаньчууд ч тэдгээр булшнаас тонож сүйтгэсэн байх магадлал өндөр байна.

Одоогоор илэрч мэдэгдээд буй үүдэвч бүхий дөрвөлжин хэлбэрийн гадаад байгууламжтай Хүннүгийн язгууртны булшнууд Монголын төв, зүүн, баруун бүс нутаг, мөн Өвөр Байгал, Тувагаас л илэрч олдсон бөгөөд тархалтын ерөнхий зургийг харахад хойд тал руу илүүтэй шахсан, нутгийн гүнд байрлаж буй онцлогийг төвөггүй ажиглаж болно. Энэ нь шаньюй болон түүнтэй ойр төрлийн язгууртан дээдсийг булшинд онголохдоо дайсан этгээд шууд нэвтэрч хүрэх боломж багатай, харьцангуй аюул ослоос хол байлгахад анхаарч байсны нэг нотолгоо байж болох юм. Түүнээс гадна эдгээр үүдэвч бүхий дөрвөлжин хэлбэрийн гадаад байгууламжтай Хүннүгийн язгууртны булшнуудын нүхийг шатлан багасгаж ухсан маш гүнзгий байдаг ба нүхийг булахад олон давхар чулуун чигжээс хийсэн байдаг. Одоогоор мэдэгдэж буй хамгийн гүн нүхтэй булш Гол мод-II дурсгалт газарт малтлага хийсэн 1-р булш бөгөөд нүхний гүн 22 м хүрсэн бол Гол модны 20-р булшны 18 м, Ноён уулын 20-р булшны нүх 18.3 м гүн байв. Ийм гүнзгий нүх ухаж оршуулга үйлдэхээс гадна нүхийг булахад хэдэн арван тонноор хэмжигдэх чулуудыг ашиглан чигжээс хийсэн нь тонуулчдаас сэргийлэх шийдэл гэхээс өөрөөр тайлбарлахад төвөгтэй юм. Чигжээс чулууд нь дурсгалын ойр орчимд байх боломжгүй бөгөөд нилээд зайтай газраас зориуд зөөж авчирсан байдаг нь булшны нүхний чигжээс буюу хамгаалалтын байгууламжийг хийхэд их

анхаарч байсныг харуулдаг.

Хүннүгийн язгууртны булшийг малтан судалсан археологичдын дунд их яригддаг нэг зүйл нь хэт гүнзгий нүхийг ухахад хөрсний нуруулт үүсдэг ба шороо чулууг зөөхөд хүндрэл бэрхшээл учирдаг явдал юм. Түүнчлэн нүхийг ухахад шатлан багасгаж нуруултаас сэргийлсэн байхын зэрэгцээ оршуулсан хүний зэрэг дэвтэй холбоотойгоор нүхийг том, жижиг үйлдсэн гэх мэт анхнаас нь нарийн тооцоолж хийсэн нь ажиглагддаг билээ. Энэ нь Хүннүгийн язгууртны булшийг бүтээх үйл явц, ялангуяа оршуулга хийх газар сонгох, нүхийг ухаж бэлтгэх ажиллагаа нь нарийн тооцоо, төлөвлөгөөний дагуу хийгддэг байсныг харуулна. Өөрөөр хэлбэл, язгууртны булшны гадаад болон дотоод байгууламж гэдэг нь инженерийн нарийн тооцоолол, тусгай мэргэжилтний удирдлага, зохион байгуулалт дор бүтээгдсэн гэсэн үг. Тиймээс бүтээн байгуулалтын ажлыг барилга байгууламж барьсан туршлагатай, тооцоолол зураг төсөл хийх чадвар, мэдлэгтэй хэн нэгэн удирдан чиглүүлж хийжээ хэмээн үзэхээс аргагүй юм.

Хүннүчүүдийн хувьд барилга байгууламж барих, газар шорооны ажил хийхэд олзны болон дагаж орсон өмнө зүгийн гаралтай суурин иргэдийг ихээр ашигладаг байжээ. Дээр дурдсан сурвалжийн мэдээнд хүртэл “худаг гаргаж, хэрэм байгуулан, барилга байшин босгож, үр тариагаа хадгалах ажлыг цин хүмүүс (хятадаас хүннүд даган орсон хүмүүс)-г хариуцуулья” хэмээн ярилцаж байсныг тэмдэглэн үлдээсэн нь үүнийг нотолж байна.

Хүннүгийн язгууртны булшны нүхний хэлбэр, шатлан багасгаж ухсан арга барил Хятадын Цин, Хан улсын үед холбогдох том булшнуудынхтай төстэй байдаг. Зохиогч энэ талаар өмнө нь хэвлүүлсэн бүтээлд дурдаж байсан бөгөөд Цин, Хангийн үеийн булшны судалгаагаар мэргэшсэн судлаач Хуан Сяо фений судалгаанд тулгуурлан үзэхэд Хунан мужийн Чанша хотын ойролцоох Мавандуйн дурсгалт газарт малтлага хийсэн Баруун Хан улсын үед холбогдох язгууртны булш, Шанси мужийн Шанжао тосгоны Цин улсын үеийн язгууртны булш, Хубэй мужийн Фушаны Хан улсын үеийн язгууртны булш зэрэг олон дурсгалыг жишээ болгон харьцуулах боломжтой байна [Эрэгзэн, 2010: 280-281; 黃曉芬, 2006: 87]. Тиймээс Хүннүгийн язгууртны булшны нүхийг ухаж бэлтгэхэд инженерийн мэдлэг, чадвартай суурин иргэдийг ашигласан ба үүний баталгаа нь сурвалжийн мэдээнээс гадна булшны нүхний хэлбэр, шатлан багасгаж ухсан арга барил зэрэгт ажиглагдаж байна. Иймэрхүү санааг Оросын археологич Н.Полосьмак Ноён уулын дурсгалын малтлагын үр дүнг хэвлүүлсэн бүтээлдээ дурдаж

байв [Полосьямак нар, 2008: 85-87].

Нэг сонирхолтой зүйл нь үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн язгууртны булшнууд ихэвчлэн элсэрхэг хөрстэй газарт байрлана. Зөвхөн Ноён уул болон Бэлхийн амны булшнууд хатуу чулуурхаг хөрстэй газарт бий. Өөр нэг онцлог нь элсэрхэг хөрстэй газрын булшнууд уулын арын тэгш дэвсэг газарт байрлах бол Ноён уул, Бэлхийн амны булшнууд уулын энгэрт талд байрладаг ялгаатай. Хүннүгийн цагариг хэлбэрийн жижиг булшнууд бүгд уулын энгэрт талд байрлах бөгөөд энэ шинжээр Ноён уул, Бэлхийн амны язгууртны булшнуудын байрлал зүй илүү уламжлалаа хадгалсан ажээ⁶.

Энд он цагийн хамаарлын асуудлыг эргэн харвал сонирхолтой дүр зураг гарахаар байна. Ноён уулын дурсгалаас илэрдэг чий будагтай Хан хийцийн сав суулга, торго нэхмэл зэрэг үйлдвэрлэсэн он цагийг мэдэх боломжтой олдворууд бүгд НТӨ I зууны төгсгөл, НТ I зууны эхэн хагаст холбогддог. Радио-карбон шинжилгээний дүн ч үүнийг давхар нотлож буй талаар бид өмнөх хэсэгт дурдсан. Үүнээс үзэхэд Ноён уулын булшнууд үүдэвчтэй дөрвөлжин хэлбэртэй язгууртны булшнууд дотор хамгийн эрт үед холбогдох боломжтой. Газар сонголтын онцлогоос харахад үүдэвчтэй том булшнуудыг анх Ноён уул, Бэлхийн ам зэрэг газруудад байгуулсан байх магадлал өндөр байна. Малтлага судалгааны явцад хийсэн ажиглалтаар ч энэ нь илүү мэдэгддэг. Ноён уул, Бэлхийн амны хөрс маш их чулуутай, хатуу бөгөөд гүнзгий ухахад их хүндрэлтэй байдаг. Түүнтэй харьцуулахад Дуурлиг нарс, Гол мод, Гол мод-II зэрэг дурсгалт газрын булшнууд элсэрхэг газарт байрлах бөгөөд хөрсний онцлогоос харахад гүнзгий ухахад хүндрэл нь харьцангуй бага юм. Эндээс үзэхэд хүннүчүүд үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн гүнзгий нүхтэй булшнуудыг анх Ноён уул, Бэлхийн ам зэрэг газруудад байгуулсан бөгөөд ингэхдээ газар сонголтын уламжлалаа илүүтэй баримталж уулын энгэрт талд оршуулга хийж байсан бололтой. Харин уулын энгэрт газар нь чулуу ихтэй, хатуу хөрстэй тул хожим илүү хялбар ухах боломжтой элсэрхэг хөрстэй уулын арын тэгш газрыг сонгодог болсон хэмээн таамаглаж болох бөгөөд үүнийг дурсгалт газруудын булшны холбогдох он цаг илүү бататгаж байна.

Ноён уулын 6-р булшийг хятад гаралтай Хан хийцийн чий будагтай олдворуудын бичээс, торго

⁶ Зохиогч докторын зэрэг горилсон бүтээлдээ Хүннүгийн булшны тархац, газар зүйн онцлог шинжийн талаар дэлгэрэнгүй өгүүлсэн бөгөөд түүн дотор Ноён уул, Бэлхийн амны дурсгал болон Гол мод, Гол мод-2, Дуурлиг нарсны дурсгалуудын байрлал, газар (хөрс) сонголт зэрэгт ялгаа байгааг дурдаж, Ноён уул, Бэлхийн амны дурсгалын байришл жирийн жишиг булшнуудтай төстэй уулын энгэрт газарт байрлаж буйг онцлон тэмдэглэсэн буй. Энэ талаар Э.Рэгзэн (Г.Эрегзэн). *몽골 흉노 무덤 연구* (Монголын Хүннү булшны судалгаа). 서울대학교 박사학위논문, 2009 бүтээлээс дэлгэрүүлэн үзэх боломжтой.

нэхмэл дээрх дүрс үсэг, ялангуяа чий будагтай аяганы ёроол нэмж сийлсэн “Шанлин” хэмээх 2 дүрс үсэгт тулгуурлан “Үжүлю жоди шаньюйн булш” хэмээн үзэх судлаачид гарч байсан. Үүний гол жишээ нь Оросын судлаач А.Н. Бернштамын таамаглал юм. Мэдээж энэ таамаглал төдий л үндэстэй биш бөгөөд Ноён уулын 6-р булшийг онцгойлон “Үжүлю жоди шаньюйн булш” хэмээн үзэх нь үндэслэл нотолгоо багатай, өөрөө олон асуудлыг дагуулдаг. Үүнд нотолгоо болгож буй Цяньпингийн 2-р онд бүтээсэн болохыг өгүүлсэн бичээстэй аягатай төстэй утгатай, ижил он цагт холбогдох чий будагтай аяга тэрхүү булшны дэргэдэх Симуковын малтлага хийсэн 5-р булшнаас илэрсэн бөгөөд ижил дүрс үсэг бүхий торго нэхмэлүүд өөр хэд хэдэн булшнаас илэрсэн тул заавал ч үгүй 6-р булшийг онцолж хэн нэгэн шаньюйтай холбож үзэх боломжгүйг харуулна. Харин анхаарууштай зүйл нь Ноён уулын дурсгалаас илэрч буй зүйлсийн дийлэнх нь НТӨ I зууны төгсгөл, НТ I зууны эхэн буюу Баруун Хан улсын төгсгөлөөс Ван Маны байгуулсан Шин улсын үед холбогдож буй явдал юм.

Энэхүү түүхэн цаг үед Хүннүгийн төрийг Хуханье шаньюйн удмынхан барьж байв. Хуханье шаньюй НТӨ 33 онд Хан улсад айлчилж, түшмэг улс болох гэрээ байгуулж, Хан улсын хааны ордны гүнжийг буулган авсан бөгөөд түүний удмын шаньюй нар Ван Маны үе хүртэл Хан улсад айлчлал хийж, хятад гүнж авч байсан төдийгүй Хан улсаас их хэмжээний бэлэг шан харамж хүртэж байсан талаар сурвалжийн мэдээ баримт бий. Энэ үеэс Хүннү гүрэнд Хан улсын нөлөө илүүтэй нэмэгдсэн нь тодорхой бөгөөд энэ нь булш оршуулгын бүтэц, хэлбэрт нөлөөлсөн байх магадлалтай.

Дээр өгүүснийг эргэн тодруулвал НТӨ I зууны эхний хагаст буюу сурвалжид тэмдэглэснээр НТӨ 77 онд ухуаньчууд Хүннүгийн тэнгэрт хальсан шаньюйн булшийг тонож сүйтгэжээ. Хаад язгууртны булшийг сүйтгэсэн явдал хүннүчүүдийн хувьд ихээхэн доромжлол, басамжлал болсон бөгөөд тэр даруй их цэрэг хөдөлгөн ухуаньчуудыг довтлон цохисон нь өс хонзонгийн сэдэлтэй үйлдэл гэж үзэж болохоор байна.

Шаньюйн булш оршуулгыг тоносон явдал язгууртны булшнуудыг дайсан этгээд халдахаас сэргийлэх шаардлагатайг хүннүчүүдэд ойлгуулж, тэд язгууртны булш оршуулгыг нутгийн гүнд, хялбархан хүрэх боломжгүй газарт байгуулж эхэлсэн болов уу хэмээн таамаглаж байна. Үүний нотолгоо нь одоогоор илэрч тэмдэглэгдсэн үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн гадаад байгууламжтай Хүннүгийн язгууртны булш бүхий томоохон оршуулгын газрууд бүгд нутгийн гүнд, өмнөд хилээс алс зайтай газруудад байгаа

байршил зүйн онцлог гэж болно. Түүнээс гадна тонуулчдаас сэргийлэх үүднээс булшны нүхийг илүү гүн ухдаг болсон, хол газраас зориуд тээвэрлэн авчирсан чулуудаар чигжээс хийж хамгаалалтын байгууламж үйлдэх болсон байна.

Шаньюйн булшийг тонож сүйтгэсэн явдал Хуяньди шаньюйн үед тохиосон бөгөөд түүний дараа их самуун цаг тохиосон тул булш оршуулгад анхаарал хандуулах боломж олдсон эсэх эргэлзээтэй. Харин “5 шаньюйн хямрал”-ын дараа шаньюй болсон хүн нь Хуханье шаньюй бөгөөд түүнийг оршуулах үед цаг төр илүү тогтвортой, намжмал болсон болохоор энэ үеэс язгууртны булшийг тонуулчдаас сэргийлэхэд анхаарал хандуулах боломж бүрдсэн байв. Мөн энэ үед Хан улстай харилцаа илт сайжирсан нь энэ чиглэлийн мэргэжилтнүүд Хүннүд ирж, туслах боломж илүү нээлттэй болсон гэж үзэж байна.

Түүнээс гадна анхаарч үзүүштэй өөр нэг чухал асуудал нь үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн гадаад байгууламжтай Хүннүгийн язгууртны булшнуудын гадаад, дотоод байгууламжийн хэмжээ, дагалдуулсан зүйлс гэх мэт олон хэв шинжүүд нь зэрэг дэвийг илэрхийлж байдаг төдийгүй улсаас нэгдсэн жишиг тогтоож мөрдүүлсэн байх магадлал өндөр буй явдал. Хан улсад ийм жишиг аль эрт тогтсон байх ажээ. Жишээлбэл, Жоу улсын үеэс уламжилж ирсэн “Ёс зүйн тухай” болон “Ёс зүйн тэмдэглэл” сурвалжид “тэнгэрийн хүүг 4 давхар авсанд оршооно” гэхийн зэрэгцээ “хаадын оршуулга 3 давхар, вангуудынх 2 давхар, түшмэдийнх 1 давхар, цэрэг дайчдынх давхар биш байна” хэмээн тэмдэглэсэн бол Байлдаант улсын үеийн их сэтгэгч Сүнзийн бичсэн “Ёс зүйн ном”-нд “тэнгэрийн хүүгийн авс, хашлага нь 7 давхар, вангуудынх 5 давхар, түшмэдийнх 3 давхар, цэрэг дайчных 2 давхар байна” хэмээн тэмдэглэсэн байдаг ажээ. Хятадад малтлага судалгаа хийсэн Хангийн язгууртны булшнуудад 2 давхар хашлага дотор 5 давхар авсанд хийсэн оршуулга, 1 давхар хашлага дотор 4 давхар авсан хийсэн оршуулга зэрэг түгээмэл тохиолддог байна. Хан улсын үеийн язгууртны булшнуудад хэдийгээр дурдсан сурвалжуудад тэмдэглэсэнтэй шууд дүйцэх бүтэц зохион байгуулалт олон таардаг боловч дүйцэхгүй байх нь ч түгээмэл ажээ (신용민, 2000: 83-84). Эндээс үзэхэд Хятадад язгууртны булш оршуулгыг үйлдэхэд зэрэг дэвийн ялгааг харгалзан бүтцийг нь таацуулан хийдэг байсан нь мэдэгдэх бөгөөд ийнхүү оршуулгын байгууламжийг тухайн оршуулж буй хүний зэрэг дэв, нийгэмд эзлэх байр суурийг харгалзан бүтээх явдал хэлбэршин тогтож, тодорхой дэг жаягтай болсон байжээ. Ийм уламжлал Жоу улсын үеэс эхлэн Хан улсыг хүртлэх хугацаанд хувьсан хөгжиж байсан нь сурвалжийн мэдээ баримтаар

батлагдаж байгаа юм.

Хүннүчүүдийн хувьд Хан улстай хамгийн ойр харилцаатай болж, төрийн үйл хэрэгт өмнөд хөршөөс илгээсэн зөвлөх түшмэдийн оролцоо харьцангуй өндөр байсан цаг хугацаа нь Хуханье болон түүний удмын хэдэн шаньюйн төр барьсан цаг хугацаа гэдгийг бид сурвалжийн мэдээ баримтаас хялбархан ойлгож болно. Тиймээс Хан улсад хэлбэршин тогтсон байсан язгууртны булш оршуулга үйлдэхэд түгээмэл ашиглагдаж байсан оршуулсан хүний зэрэг дэвийг харгалзан оршуулгын байгууламжийн бүтцийг тогтоодог хэв ёсны нөлөө Хуханье шаньюйн үеэс Хүннүгийн язгууртны оршуулгад тусаж, өөрчлөлт ороход хүргэсэн байж магадгүй юм.

Дээр өгүүлсэнд тулгуурлан үзэхэд олдвор эд зүйлсийн бүрдэл, холбогдох он цаг, газар сонголт зэрэг олон хэв шинжээр Ноён уулын булшнууд үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн булшны төрөл дотор хамгийн эрт үед холбогдох боломжтой бөгөөд цаг хугацааны давхцал, тухайн үеийн улс төрийн нөхцөл байдал зэргээс үзэхэд Хуханье шаньюйн үеэс үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн булшийг хүннүчүүд байгуулж эхэлсэн хэмээн таамаглаж болохоор байна.

Хүннүгийн язгууртны булшны хувьсал хөгжлийн үйл явцын талаарх төсөөлөл

Хүннүгийн үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн гадаад байгууламжтай язгууртны булшнууд НТӨ I зууны төгсгөлд дэлгэрч эхэлсэн хэмээн үзвэл ийм хэлбэрийн булш бий болохоос өмнө хүннүчүүдийн язгууртны булш ямар хэлбэр, бүтэцтэй байсан бэ гэдэг асуулт гарна. Үүний хариулт байж болохоор дурсгалыг бид саяхан илрүүлж судалсан. Монгол-Солонгосын хамтарсан экспедиц Төв аймгийн Баянцагаан сумын нутагт орших Чихэртийн зоо хэмээх дурсгалт газарт 2016-2017 онд малтлага судалгаа хийсэн юм. Чихэртийн зоогийн дурсгалт газар говь, тал хээрийн заагт Монголын төв хэсэгт орших бөгөөд энд нийт 300 гаруй булш тархжээ. Гадаад хэлбэрийн хувьд Хүннүгийн жирийн жижиг булш хэмээн үзэж ирсэн цагариг хэлбэрийн чулуун байгууламжтай хэлбэрийн хувьд төстэй боловч хэмжээний хувьд харьцангуй том булшнуудтайгаар онцлог. Энд хамгийн том нь 50 м голчтой бол дундаж нь 20 м голчтой том булшнууд олон бий.

Чихэртийн зоо дурсгалт газарт төслийн хээрийн шинжилгээний анги 2016 онд 2 булш (4, 9-р булш), 2017 онд 4 булш (199, 200, 201, 229-р булш) малтан шинжилсэн. 2016 онд дурсгалт газрын баруун өмнөд хэсэгт бүлэглэн орших булшнуудаас 2-ыг сонгон малтсан. Бидний сонгож малтлага судалгаа хийсэн булшний нэг нь 17 м

голчтой харьцангуй том (4-р булш), нөгөө нь 7.5 м голчтой дундаж хэмжээний булш (9-р булш) болно [Эрэгзэн нар, 2020].

Харьцангуй том хэмжээтэй 4-р булшны хувьд газрын өнгөн хөрсөн дээр цагариг хэлбэрийн чулуун дараасаар танигдаж байв. Өнгөн хөрсийг 20х20 м хэмжээтэйгээр талбай сонгон хуулж цэвэрлэснээр гадаад чулуун байгууламж тодорхой ажиглагдахуйц болсон. Энэ булшны хувьд гадаад чулуун байгууламж нь зөв цагариг хэлбэртэй бөгөөд ялангуяа дараасын дотор талын ирмэгүүд жигд өрлөгтэй, харин гадна захын чулууд нурж тарсан байдалтай байсан. Булшны гадаад чулуун байгууламж ийм зөв цагариг хэлбэртэй байгаа явдал нь Хүннүгийн жирийн жижиг булшны гадаад чулуун байгууламжийг цагариг, дугуй, дөрвөлжин гэх мэтээр янз бүрээр тодорхойлж ирсэн маргаантай асуудалд хариулт өгөхүйц мэдээллийг өгсөн чухал ач холбогдолтой баримт хэмээн үзэж байна.

4-р булшны гадаад чулуун дараасын хэмжээ ч өнөөг хүртэл малтлага хийсэн жирийн цагариг хэлбэрт булшнууд дунд хамгийн томд тооцогдоно. Гэхдээ энэ булш Чихэртийн зоогийн дурсгалт газрын хамгийн том булш биш юм. Тэгэхээр Хүннүгийн цагариг хэлбэрт булшнууд дунд язгууртны булштай дүйцэхүйц гүн нүхтэй дурсгалууд байх боломжтойг харуулсан. Оршуулгын хэсгээс харьцангуй том хэмжээтэй дүрээр зангидаж хийсэн модон хашлага илэрсэн. Энэ дүрээр хашлаганы хэмжээ мөн л язгууртны гэгдэх том булшнуудтай дүйцэхүйц юм. Сонирхолтой нь дүрээр хашлага дотроос модон авсны ул мөр мэдэгдээгүй ба эрэгтэй, эмэгтэй 2 хүний ясны үлдэгдэл илэрсэн. Булш эрт цагт тоногдож сүйтгэгдсэн байснаас оршуулгын хэсгийн зохион байгуулалтыг мэдэх боломжгүй болсон боловч эмх замбараагүй холилдон яснууд дунд эр, эм 2 хүний яс байгаа нь уг булшинд 2 хүнийг оршуулсан байх магадлал өндөр байна. Энэ таамаглалыг дэмжиж буй өөр нэг баримт нь дүрээр хашлагын хэмжээ болно. Өмнө нь эр, эм хоёрыг хамтад нь оршуулсан булш Архангай аймгийн Наймаа толгойн дурсгалд тохиолдож байсан. Тиймээс энэ таамаглал огт үндэслэлгүй зүйл биш юм. Оршуулгын хэсэгт байсан дүрээр хашлагын гадна талаар 3-5 см жигд хэмжээтэй жижиг чулуугаар чигжээс хийсэн байв. Энэхүү чигжээс болгосон чулууд нь галт уулын гаралтай хүрмэн чулууг зориуд буталж жигд хэмжээтэйгээр жижиглэсэн байсан. Оршуулгын модон хашлагын гадна талаар жижиг хайрга чулуугаар чигжээс хийж хамгаалсан тохиолдол өмнө нь Ноён уулын 22-р булш гэх мэт язгууртны дурсгалд ажиглагдаж байсан. 4-р булш тоногдсон байснаас олдвор

эд өлгийн зүйлс харьцангуй бага олдсон. Соёо хэлбэрийн хаш унжлага чимэг, хэдэн ширхэг чулуун сувс, шавар ваарны хагархай, маш их зэвэрч бутарч муудсан төмөр амгай, зуузайн үлдэгдэл зэрэг л уг булшнаас илэрсэн.

Чихэртийн зоод малтлага хийсэн 4-р булшны оршуулгын хэсэгт дүрээр зангидаж хийсэн том хэмжээт модон хашлагатай, хашлагын гадна талаар зориуд жижиглэсэн чулуугаар чигжээс хийсэн, хашлага дотор хүнээ оршуулахдаа модон авс хэрэглэсэн ул мөргүй байгаа, хос оршуулгатай байгаа зэрэг бүтэц, зохион байгуулалтын хэв шинжээр өмнө нь малтлага судалгаа хийсэн Хүннүгийн жирийн цагариг хэлбэрт булшнууд дунд нилээд өвөрмөц дурсгалд тооцогдох боломжтой байна. Дурдан буй бүтэц, зохион байгуулалтын онцлог шинжүүд нь Хүннүгийн дурсгалаас он цагийн хувьд өмнөх шатад холбогдох Пазырыкийн булшнуудтай төстэй байна. Тиймээс бид энэ булшийг Хүннүгийн дурсгалууд дунд харьцангуй эрт үед холбогдоно хэмээн таамагласан бөгөөд малтлагын явцад мод, яс, органик эдийн үлдэгдэл зэрэг хэд хэдэн зүйлээс дээж авч он цагийг нарийвчлан тогтоосон. Дээжийн шинжилгээний хариу 2100 ± 40 жилийн өмнө буюу 95.4 хувийн магадлалтай тохиолдолд НТӨ 350-1 он, 68.2 хувийн магадлалтай тохиолдолд НТӨ 180-50 онд холбогдохоор гарсан нь бидний таамаглал зөв байсныг баталж өгсөн гэхэд болно.

Дурсгалт газарт малтлага судалгаа хийсэн 9-р булш нь дээрх булшны зүүн талд 10 м орчим зайд байрлана. Гадаад чулуун байгууламжийн хувьд цагариг хэлбэртэй, голч нь 7.5 м байв. Малтлагын явцад Хүннүгийн жирийн булшнуудаас ялгарах онцлог зүйл ажиглагдаагүй. Булшны оршуулгын хэсэг эрт тоногдож сүйтгэгдсэн тул оршуулга болон эд өлгийн зүйлс анхны байрнаас их хөдлөж эмх замбараагүй болсон байлаа. Сонирхолтой нь энэ булшнаас ч гэсэн эрэгтэй, эмэгтэй 2 хүний ясны үлдэгдэл илэрсэн. Гэхдээ нэг хүний яс нь нэлээд дээрээс голчлон олдсон тул оруулмал оршуулга юм уу дагалдуулсан оршуулга хэмээн таамаглаж байна.

Булшны оршуулгын хэсэгт байгалийн ургаа хадыг ашиглан тахилын тавцан болгож 2 адуу, 2 унага зэрэг малын ясаар хойлго хийсэн агаад тэдгээрийн дор оршуулгын толгой тал хэмээн таамагласан хойд хэсгээс чий будагтай модон таваг олдсон. Мөн нүхний хойд хагасаас маш муу хадгалалттай төмөр тогооны хэсгүүд, олон хэсэг болж бутарсан шавар ваарны хагархай зэрэг илэрсэн бөгөөд үүнийг чий будагтай таваг зэрэгтэй хамт байсан тахилын зориулалттай сав суулгын зүйлс хэмээн үзэж байна.

9-р булшнаас дээр өгүүлсэн сав суулгын

зүйлсээс гадна зориулт нь тодорхойгүй саваа хэлбэрийн модон эдлэлийн үлдэгдэл, адуу малын тоног хэрэглэлийн үлдэгдэл болох ихэд зэвэрч муудсан хазаарын төмөр амгай, төмөр зуузайн үлдэгдэл, амьтны дүрст хээтэй хазаарын хүрэл товруу 4 ш, хээгүй дугуй хэлбэрийн жижиг хүрэл товруу 1 ш, хазаарын сагалдарганы сурны үзүүрийн чимэг бололтой гонзгой хэлбэрийн хүрэл чимэг 1 ш олдсон байна. Эдгээрийн дотроос амьтны дүрст хазаарын хүрэл товруу нь өмнө малтлага хийсэн Хүннү булшнаас илэрч байгаагүй ховорхон олдвор юм. 4 товруу бүгд ижил хэлбэртэй, дүрслэл нь ч төстэй байна. Нүүрэн талын дугуй гадаргууд зохицуулан амьтныг урдаас харсан байдлаар дүрслэсэн бөгөөд амьтны хошуу, чих зэрэг толгойн тал хэсгийг баримлын маягтай товойлгон гаргаж цутгажээ. Харин 4 хөлийн сарвууг толгойн доод талд нарийн товгор зураасаар дүрслэсэн нь зохиомжийн хувьд их гоёмсог харагдуулна. Энэ эдлэл дээр дүрслэгдсэн амьтан нь соотон чихтэй, бүлтгэр том нүдтэй, гурвалжин урт хошуутай, урт хэлээ унжуулсан байдалтай байгаа нь чоно, эсвэл ирвэсийн төрлийн амьтантай төстэй харагдана. Бид энэ амьтны дүрсийг ирвэс хэмээн тодорхойлж байгаа боловч бодит амьтан бус домгийн шинжтэй хийсвэр дүрслэл байхыг ч үгүйсгэхгүй юм. Үүнтэй төстэй зохиомжоор урласан амьтны дүрст дугуй чимэглэлүүд манай улсын нутаг болон Өвөр Монголын нутгаас түүвэр байдлаар олдсон байдаг. Тэдгээр нь голчлон баавгайтай төстэй амьтны дүрстэй байна. Он цагийн хувьд судлаачид ийм хүрэл чимгийг НТӨ III-I зуунд холбогдуулан үзжээ [Emma C.Bunker et al, 1997, 263-264].

2017 онд хамтарсан төслийн судалгааны анги Чихэртийн зоод 4 булш малтан шинжилсэн. Эхний жил малтлага хийсэн 2 булш нам дор газар байрлах бол энэ жилийн малтлага хийсэн дурсгалууд өндөрлөг газарт байрлана. Үүнээс 201 дугаартай булш нь цагариг хэлбэрийн чулуун дараастай, дараасын голч 20 м хүрэх харьцангуй том хэмжээтэй юм. Энэ булш зүүн талдаа 2 дагуул булштай. Дагуул булшнуудыг тархацын зурагт 199, 200 хэмээн дугаарлажээ. 201-р булшнаас баруун өмнө тийш 200 орчим метр зайд байрлах 229-р хэмээн дугаарласан нэгэн жижиг булшийг мөн малтан судалсан юм.

201-р булшны хувьд өмнө нь манай улсын нутагт малтан судалж байгаагүй том хэмжээтэй цагариг хэлбэрийн чулуун дарааст хүннү булш болно. Энэ булшны нүхийг 1 шатлан багасгаж 12 м гүн ухсан байсан нь ч энэ хэлбэрийн булшин дунд одоогоор хамгийн гүн нь болох юм. Нүхний ёроол 4.7x3.2 м хэмжээтэй том модон бунхан байрлуулсан байсан нь ихэд элжирч муудан доош цөмөрч нурсан байв. Баримжаагаар тооцоход бунхны өндөр 1.5 м орчим байсан бололтой. Модон бунхны таг дээрээс 4

дугуйтай 2 морин тэрэгний үлдэгдэл олдсон. Энэ булшнаас олдсон морин тэрэг чий будагтай агаад бунхны зүүн талын хананд нааж тавьсан байдлаар олдсон нь алт шармал хүрэл тоногтой, баруун хананд тавьсан нь төмөр тоногтой байв. Өмнө нь Хүннүгийн язгууртын булшнаас чий будагтай ёслолын морин тэрэгний үлдэгдэл хэд хэд илэрсэн байдаг. Тэдгээр нь бүгд 2 дугуйт тэрэг байсан бол Чихэртийн зоогийн дурсгалаас илэрсэн тэрэгнүүд 4 дугуйт байсан нь анхны тохиолдол болж байна. Энэ булшийг эрт цагт тонож сүйтгэсэн байснаас модон бунхан дотор олдвор эд өлгийн зүйлс бараг үлдээгүй ажээ. Тонуулчид бунхны тагийг зүүн хойд хэсгээр нь цөм цохин дотогш нэвтэрсэн ба бунхны модон шалыг ч ховхлон шалгаж үзсэн ул мөр мэдэгдэж байхыг бодоход элжирч нурахаас өмнө орж их чөлөөтэй тонож сүйтгэсэн болох нь тодорхой байв. Бунхны хойд захаас маш муу хадгалалттай чий будагтай савны үлдэгдэл, нимгэн алтан чимэглэлийн хэсэг, хүрэл толины хагархай, дэнгийн цөгцний суурь хэмээн таамагласан дугуй хэлбэрийн цоолбор хээтэй хүрэл эдлэл зэрэг зүйлс илэрсэн нь тонуулчдын тоолгүй хаяж явсан зүйлс ажээ. Булшийг малтах явцад хэдэн төрлийн хүрэл тогооны хэсгүүд, нүхэлсэн чулуун булнууд илэрч байсан. Хүрэл тогооны хагархайнуудын хувьд тонуулчдын хаяж гээсэн зүйлс бололтой. Харин нүхэлсэн чулуун булнууд нь том жижиг хэмжээтэй бөгөөд эдгээр нь булшны нүхийг ухахад хэрэглэсэн хөшүүргийн механизмийн хэсэг болов уу хэмээн таамаглаж байна. Хэрэв тийм бол уг олдворууд нь булшны нүхийг ухахад хүннүчүүд оньсон техник ашиглаж байсныг илтгэх чухал хэрэглэгдэхүүн болох учиртай юм.

201-р булш нь зүүн талдаа 2 жижиг дагуул булштай. Дагуул булшнуудыг хойноос урагш цувуулан 1 эгнээнд байрлуулсан төдийгүй том булшнаас ижил зайд тавьсан зэрэг шинжээс харвал зориуд дагуул болгож үйлдсэн байдал ажиглагдана. Тиймээс бид 201-р булшийг малтан шинжлэхдээ энэхүү 2 дагуул булшийг хамтад нь малтсан юм. Дагуул булшнуудаас модон авс бүхий түгээмэл тохиолдог хүннүгийн жирийн жижиг булшны зан үйл ажиглагдсан. Харин сонирхол татах зүйл нь сумны хүрэл болон ясан зэвнүүд байв. Ийм хүрэл зэв Монгол болон Өвөр Байгалд олон тоогоор малтлага судалгаа хийсэн хүннүгийн жижиг булшнуудаас маш ховор илэрсэн бөгөөд хэлбэрийн хувьд түрүү төмөр зэвсгийн үеийн булшнаас илэрч байжээ. Холбогдох он цагийг нь НТӨ VI-II зуунд хамруулан үздэг байна.

Чихэртийн зоод малтлага судалгаа хийсэн 201-р булш нь бүтэц зохион байгуулалтын хувьд нэлээд өвөрмөц, харьцангуй эртний шинжийг агуулсан ба илэрч буй олдвор эд өлгийн зүйлс нь НТӨ II зуунаас өмнөх үеийн зүйлстэй ижилсэж буй зэрэг нь

2-р хүснэгт. Чихэртийн зоо дурсгалт газарт малтлага судалгаа хийсэн Хүннү булшнаас авсан дээжийн радио-карбон задлан шинжилгээний дүн

Д/д	Дурсгалын дугаар	Лабораторийн нэр	Дээжийн материал	$\delta^{13}\text{C}$ (%)	$1\sigma^{14}\text{C}$ age (yr BP)	95.4% (2 σ) cal age ranges (BC)	Дээжийн лабораторийн н дугаар
1	Чихэртийн зоо 4-р булш (2016 оны малтлага)	Carbon Analysis Lab. Korea	Авсны мод (coffin wood)	-21.5	2100±40	350-1 BC (96.4%)	IAEA C8-3
2	Чихэртийн зоо 201-р булш (2017 оны малтлага)	Carbon Analysis Lab. Korea	Авсны мод (coffin wood)	-24.8	2130±30	350-50 BC (100%)	IAEA C7
3	Чихэртийн зоо 201-р булш (2017 оны малтлага)	NSF-Arizona	Ширэмнээс ялгаж авсан радио-карбон (Cast iron)	-24.9	2195±20	360-197 BC (100%)	AA111162
4	Чихэртийн зоо 201-р булш (2017 оны малтлага)	NSF-Arizona	Модны нүүрс (Charcoal)	-24.6	2230±20	380-206 BC (100%)	AA111164

малтлага судалгаа хийсэн Хүннү булшнууд дотор хамгийн эрт үед холбогдох боломжтойг харуулж байв. Тиймээс бид энэ булшны модон бунхны модноос дээж авсан ба олдсон тэрэгний ширмэн цөнгөөс нүүрстөрөгч ялган авч шинжилгээнд өгсөн. Мөн хүрэл эдлэлд наалдсан модны нүүрснээс дээж авч он цаг тогтоох шинжилгээг хийлгэсэн юм. Үүний үр дүнд бунхны модны он цаг 2130 ± 30 жилийн өмнө буюу НТӨ 350-50 он, ширмэн цөнгөөс ялгаж явсан нүүрстөрөгчийн нас 2195 ± 20 жилийн өмнө буюу НТӨ 360-197 он, хүрэл эдлэлд наалдсан шатсан модны нүүрсний дээжийн нас 2230 ± 20 жилийн өмнө буюу НТӨ 380-206 онд тус тус холбогдохоор гарсан бөгөөд байгалийн шинжлэлийн аргаар тогтоосон он цагийн хамаарал нь 201-р булш хамгийн багадаа НТӨ I зууны эхний хагас, цаашлавал НТӨ III-II зуунд холбогдох боломжтойг харуулж байна [Эрэгзэн нар, 2020: 382-383].

Хэрэв ингэж үзэхэд хүрвэл Чихэртийн зоогийн дурсгал нь Монгол болон Өвөр Байгалын бүс нутагт малтлага хийсэн Хүннүгийн булшнуудаас хамгийн эртний он цагт холбогдох дурсгал болохоор байна. НТӨ II зууны үе бол Хүннү гүрэн хүчирхэг байсан цаг үе билээ.

Хүннү судлалын судлаачдын дунд Хүннүгийн уг гарвал болон тэдний соёлын талаар хэд хэдэн маргаантай асуудлууд байдаг. Нэгдүгээрт, Хүннүчүүдийн уугуул газар нутгийн тухай асуудал бөгөөд ихэнх судлаачид Хүннүгийн уугуул нутгийг одоогийн Өвөр Монголын Ордос хэмээн үздэг. Ийнхүү үзэх болсон шалтгаан нь Монгол болон Өвөр Байгалын нутгаас НТӨ II зуунаас өмнө үед буюу Хүннү гүрний хүчирхэг үеийн дурсгал илэрч олноогүйтэй холбоотой. Хоёрдугаарт, Хүннүгийн соёлыг говийн ар болон өврийн 2 тусдаа хэлбэртэй байсан хэмээн үздэг бөгөөд энэ нь мөн л говийн арын бүс нутгаас Хүннүгийн эрт үед холбогдох

дурсгал олноогүйтэй холбоотой юм. Тэгвэл Чихэртийн зоогийн дурсгал нь эдгээр маргаантай асуудалд хариулт өгөх чухал хэрэглэгдэхүүн болж буйгаар онцгой ач холбогдолтой.

Түүнээс гадна Чихэртийн зоод малтлага судалгаа хийсэн дурсгал нь цагариг хэлбэрийн чулуун дарааст булшийг Хүннүгийн жирийн иргэдэд холбогдуулан үзэж ирсэн үзэл баримтлалыг өөрчлөж, ийм хэлбэрийн дурсгал дотор харьцангуй өндөр зэрэг зиндааны хүмүүсийн оршуулга ч байх боломжтойг нотолж өгсөн нь судалгааны өөр нэг чухал үр дүн юм. Хамтарсан төслийн баг Чихэртийн зоогийн дурсгалт газрын булшны тархцын зургийг шинээр үйлдэх явцад 50 м голчтой цагариг хэлбэрийн чулуун дарааст булш буйг ч тогтоосноор энэ хэлбэрийн булш зөвхөн жирийн иргэдэд хамаатай биш болох нь илүү тодорхой болж байна.

Өнөөг хүртэл Монголд малтлага судалгаа хийсэн Хүннүгийн булшнууд дунд он цагийн хувьд НТӨ II зуунаас урагш холбогдох нь баттай тогтоогдсон дурсгал байхгүй. Зарим нэг дурсгалыг он цагийн хувьд эрт үед холбогдоно хэмээн таамаглаж болох ч дурсгалын он цагийг зөвхөн радио-карбон аргаар тогтоосон боловч олдвор эд өлгийн зүйлс нь хэв шинжийн хувьд эрт үед холбогдох боломж тааруу байдаг байв. Тиймээс ч судлаачид Монголоос илэрсэн Хүннүгийн дурсгалын он цагийг Умард Хүннү нарт холбогдолтой хэмээн үзэж, эрт үеийн дурсгал байхгүй байгаа нь Хүннүчүүд Монгол нутгийн уугуул оршин суугчид биш нүүж ирэгсэд хэмээх дүгнэлт хийхэд гол түлхэц болж иржээ. Чихэртийн зоод малтлага хийсэн Хүннү булшны хэрэглэгдэхүүн нь дээр өгүүлсэн олон маргаантай асуудалд хариулт өгөхийн зэрэгцээ шинэ таамаглал, дүгнэлтийг дэвшүүлэх боломж олгож буй тул Хүннү судлалд чухал байр суурь эзлэх дурсгал хэмээн үзэж байна.

Чихэртийн зоогийн том булшны модон бунхны бүтэц өмнөх цаг үеийн Пазырькийн соёлын булштай төстэй шинжийг агуулсан төдийгүй 4 дугуйтай тэрэг дагалдуулсан зэргээр тал нутгийн төмрийн түрүү үеийн язгууртны булшны хэв шинжийг хадгалсан тул уламжлалт булшны хэлбэр хэмээн үзэхэд хүргэж байна.

Эндээс үзэхэд Хүннүгийн язгууртны булшны бүтэц, гадаад байгууламжийн хэлбэр нь НТӨ II зуун, наашлаа гэхэд НТӨ I зууны эхний хагаст жирийн жижиг булш хэмээн үзэж ирсэн цагариг хэлбэрийн гадаад чулуун байгууламжтай, оршуулгын хэсэгт байрлах модон бунхан нь өмнөх цаг үед холбогдох Пазырькийн соёлын булшнуудтай илүү төстэй хэв шинжтэй байсан нь мэдэгдэнэ.

Өмнөх хэсэгт өгүүлсэн таамаглал, нотолгоог үүнтэй холбон авч үзвэл Хүннүгийн язгууртны булшны бүтэц, зохион байгуулалтын хөгжлийн зүй тогтолыг ерөнхий байдлаар тоймлон ойлгох боломжтой байна. Тухайлбал, Хүннүгийн язгууртны булш нь эхэн үедээ жирийн жижиг булшнуудтай төстэй цагариг хэлбэрийн гадаад чулуун байгууламжтай, гүнзгий нүхэнд том хэмжээтэй дүндэн хашлага буюу бунхантай байсан бол Хуханье шаньюйн үеэс булшны нүхийг ухах арга барил өөрчлөгдөж үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн шаталсан асар гүнзгий нүх ухах оршуулга хийдэг болсноор гадаад байгууламжийн хэлбэр нь түүнийг даган өөрчлөгджээ. Харин дотоод бүтэц нь харьцангуй уламжлалаа хадгалан үлдсэн байна. Эхэн үеийн үүдэвчтэй булшнуудыг уламжлалаа даган уулын энгэр наран эзвэр газарт тавьдаг байснаа гүнзгий нүх ухахад хялбар байхыг бодолцон уулын арын элсэрхэг хөрстэй газрыг сонгох болсон хэмээн таамаглаж болохоор байна. Тиймээс Хүннүгийн язгууртны булшийг одоогоор НТӨ I зууны дундаас өмнөх шат (Чихэртийн зоогийн дурсгал), НТӨ I зууны төгсгөлөөс НТ I зууны эхэн хагаст холбогдох дунд шат (Ноён уулын дурсгал), НТ I зууны дундаас төгсгөл хүртэлх төгсгөлийн шат (Дуурлаг нарс, Гол мод, Гол мод-II зэрэг) гэсэн он цаг, хувьсал хөгжлийн 3 шатад хуваан авч үзэх боломж харагдаж байна. Цаашид судалгаа хийсэн булшнуудын он цагийг нарийвчлан тогтоох судалгааг гүнзгийрүүлснээр энэхүү таамаглал илүү баталгаажих боломжтой юм.

Дүгнэлт

Дээр өгүүлснээс дүгнэж үзвэл, үйлдвэрлэсэн цаг хугацааг мэдэх боломжтой чий будагтай эдлэл, харьцуулсан судалгааны үр дүнд он цагийг баримжаалж болдог хүрэл толь, бичээсийн утгаар үйлдвэрлэсэн хугацааг тогтоох боломжтой торго нэхмэл зэрэг харьцангуй он цагийн хэрэглэгдэхүүн

болон органик гаралтай олдвороос авсан дээжид хадгалагдаж буй нүүрстөрөгчийн цацраг идэвхит изотопын хэмжээг тоолох аргаар он цаг тогтоодог радио-карбоны шинжилгээний үр дүн болох үнэмлэхүй он цагийн хэрэглэгдэхүүнүүд нь үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн гадаад байгууламжтай Хүннүгийн язгууртны булшнууд НТӨ I зууны төгсгөл, НТ I зууны үед холбогдохыг харуулж байна. Гэхдээ харьцангуй он цагийн хэрэглэгдэхүүний он цагийн холбогдлыг нарийвчлан авч үзвэл Ноён уулын дурсгалаас илэрсэн олдворуудын дийлэнх нь НТӨ I зууны төгсгөл, НТ I зууны эхэн хагаст, Гол мод, Гол мод-2, Дуурлиг нарс зэрэг дурсгалаас илэрсэн хүрэл толины олдворууд ихэвчлэн НТ I зууны дунд болон төгсгөлд холбогдохоор буйг анзаарч болохоор ажээ.

Ноён уул, Бэлхийн амны булшнууд уулын энгэр талд, харьцангуй хатуу хөрстэй газарт байрлах бол Гол мод, Гол мод-2, Дуурлиг нарс зэрэг дурсгалууд уулын арын тэгш дэвсгэгт, элсэрхэг хөрстэй газарт байрлана. Зохиогч энэхүү газар сонголтын ялгааг харгалзан Ноён уул, Бэлхийн амны булшнууд харьцангуй уламжлалт хэв шинжээ хадгалсан бол Гол мод, Гол мод-2, Дуурлиг нарсны булшнуудыг байгуулахад ухахад хялбар байх элсэрхэг хөрстэй газрыг сонгох болсноор уламжлалаас гажсан өөрчлөлт гарчээ хэмээн үзсэн. Он цагийн хамаарал, газар сонголтын онцлог зэргээс харахад Ноён уулын дурсгал хамгийн эрт үед, харин Гол мод, Гол мод-2, Дуурлиг нарсны булшнууд илүү хожуу үед холбогдохоор байна. Тиймээс үүнийг язгууртны булшны хувьсал хөгжлийн үйл явцыг илэрхийлэх нэг шат хэмээн таамагласан юм.

Ноён уулын дурсгалаас илэрдэг хятад гаралтай эд зүйлсүүд ихэвчлэн Хан улсаас Хүннүд бэлэг болгон өгсөн зөвхөн хаадын хэрэгцээнд зориулж үйлдвэрлэсэн эдлэл байхын зэрэгцээ тэдгээр олдворууд НТӨ I зууны төгсгөл, НТ I зууны эхэн үед холбогдож буй нь уг дурсгалт газарт оршуулсан язгууртнууд Хуханье шаньюйн ураг төрлийнхөн байх магадлалтайг харуулж байна. Хуханье шаньюйг төр барихаас өмнөхөн Хүннү гүрэн Хан улстай ужиг урт үргэлжилсэн дайн хийж, хүч нь суларсан төдийгүй говийн өмнөх газар нутагт шаньюй нутаглахаа больж, улс төрийн төв нь говийн ард гарсан энэхүү ороо бусгаа цагийг ашиглан эртний өст ухуаньчууд “тэнгэрт хальсан шаньюйн булш”-ийг тонож сүйтгэх явдал гарчээ. Өвгөдийн оршуулгыг дайсан этгээд тонож сүйтгэсэн явдал хүннүчүүдэд томоохон сургамж өгч тэд язгууртны булшийг нутгийн гүнд, гол дайсагнагч талууд оршин буй өмнөд хилээс хол газарт байгуулах болсон бололтой. Үүнийг одоо мэдэгдэж буй язгууртны булштай дурсгалуудын байршил, тархац харуулж байна хэмээн үзсэн. Түүнээс

гадна язгууртны булшийг тонож сүйтгэсэн явдал нь түүнээс сэргийлэх, хамгаалалтыг сайжруулах шаардлагатайг ойлгуулсан бөгөөд үүний илрэл нь нүхийг илүү гүнзгий ухдаг болж, тонуулчид хялбархан нэвтрэхээс сэргийлж олон үе чулуун чигжээс хийхэд хүргэсэн гэж болно. Хүннүчүүд язгууртны булшны гүнзгий нүхийг ухахад шатлан багасгаж, шороо зөөхөд хялбар шийдэл болох үүдэвч гаргах зэрэг инженерийн тооцоололд суурилсан арга технологийг ашигладаг болсон нь малтлага хийсэн язгууртны булшнууд бүгд ийм нүхтэй байгаагаас мэдэгдэнэ. Шатлан ухах арга, үүдэвч гаргах шийдлийг Хятадад Цин, Хан улсын үед түгээмэл ашиглаж байжээ. Тиймээс иймэрхүү дэвшилтэт технологийг хүннүчүүд өмнөд хөршөөс авч ашигласан, эсвэл тэдний мэргэжилтнүүдийн туслалцаа байсны ул мөр хэмээн үзэхээс аргагүй. Хүннүгийн язгууртны булшны бүтэц, зохион байгуулалтад оршуулсан хүний зэрэг дэвийг илэрхийлэх шинжүүд тод ажиглагддаг бөгөөд энэ цаг үед Хан улсад ч ийм дэг жаяг хэлбэршин тогтсон байжээ. Өмнөд хөршийн нөлөө ийнхүү язгууртны оршуулгад ч мэдрэгдэхүйц нөлөөлсөн явдлыг Хүннү ба Хан улсын харилцаа илт сайжирсан улс төрийн шалтгаантай холбож үзэхээс аргагүй юм. Зохиогч дээр өгүүлсэн улс төрийн нөхцөл байдал, нийгмийн шаардлага, дурсгалын холбогдох он цаг зэрэг олон хүчин зүйлийг харгалзан үзсний үндсэн дээр үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн гадаад байгууламжтай, шатлан ухсан гүнзгий нүх бүхий язгууртны булшны хэлбэр Хуханье шаньюй болон түүний ойр төрлийнхөн төр барьсан цаг хугацаанд шинээр бий болсон хэмээн үзсэн.

Үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн язгууртны булшны хэлбэр нийтийн тооллын зааг үед шинээр бий болсон юм бол түүнээс өмнөх цаг хугацаанд Хүннүгийн язгууртны булшнууд ямар хэлбэртэй байсан гэдэг асуулт гарах нь дамжиггүй. Үүний хариултыг Чихэртийн зоо хэмээн дурсгалт газарт малтлага хийсэн цагариг хэлбэрийн гадаад чулуун байгууламж бүхий том булшны судалгааны үр дүнд тулгуурлан тайлбарлахыг оролдсон юм. Чихэртийн зоогийн булш нь том хэмжээний модон бунхантай, 4 дугуйтай тэрэг дагалдуулсан зэрэг олон шинжээр жирийн жижиг булшнаас ялгаатай тул язгууртны оршуулга хэмээн үзэх боломжтой. Эдгээр булшнуудын он цаг хамгийн наанадаа НТӨ I зууны эхний хагас, цаашилвал НТӨ II-IV зуунд холбогдохоор гарсан болохоор үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн булшнууд бий болохоос өмнө Хүннүгийн язгууртны булшны гадаад байгууламж цагариг хэлбэртэй байжээ хэмээн үзэхэд хүргэж байна.

Тиймээс энэ бүхнийг харгалзан Хүннүгийн язгууртны булшны хувьсал хөгжлийн үйл явцыг хэлбэр, бүтэц зохион байгуулалтын хувьд цагариг

буюу дугуй хэлбэртэйгээс үүдэвчтэй дөрвөлжин болж хувьсан өөрчлөгдсөн бөгөөд он цагийн хувьд НТӨ I зууны эхний хагасаас өмнөх шат, НТӨ I зууны төгсгөлөөс НТ I зууны эхний хагаст холбогдох дунд шат, НТ I зууны дундаас хойших төгсгөлийн шат гэсэн 3 цаг үед хувааж болохоор байна. Гэхдээ энэхүү таамаглал нь одоогоор зөвхөн зохиогчийн санаа төдий тул цаашдын судалгааны үр дүнд илүү баталгаажина хэмээн найдаж байна.

Ном зүй

A report... 'Gurvan gol', 1994 - A report on the joint investigation under the Mongolian and Japanese 'Gurvan gol' Historic relic project. Tokyo,

Баруун Хан улсын бичиг, 2020 – МУИС, Монголын эртний түүхэнд холбогдол бүхий Хятад сурвалж бичиг-II, Бань гү. Баруун Хан улсын бичиг. (орчуулсан Г.Элдэв-Очир) УБ.,

Баярсайхан, Эгиймаа, 2008 - Ж.Баярсайхан, Ц.Эгиймаа. Тахилтын хотгорын 64-р булшны малтлага судалгааны үр дүн. Талын эзэнт гүрэн-Хүннү симпозиумын эмхэтгэл,

Бернштам, 1951 – А.Н.Бернштам. Очерки истории гуннов. Л.,

Доржсүрэн, 1961 - Ц.Доржсүрэн. Умард Хүннү. АС., боть 1, дэвтэр 5, УБ.,

Emma C.Bunker et al, 1997 - Emma C.Bunker, Trudy S.Kawami, Katheryn M.Linduff, Wu En. Ancient Bronzes of the Eastern Eurasian Steppes from the Arthur M.Sackler Collections. The Arthur M. Sackler Foundation,

Ерөөл-Эрдэнэ, 2015 - Ч.Ерөөл-Эрдэнэ. Хүннүгийн язгууртны оршуулгын дурсгалын судалгаа. УБ.,

Коновалов, 1976 – П.Б.Коновалов. Хунну в Забайкалье. Улан-Удэ,

Коновалов, 2008-П.Б.Коновалов. Усыпальница хуннского князя в Суджи. Улан-Удэ,

Konovalov, 2008 - P.B.Konovalov. The Burial Vault of a Xiongnu Prince at Sudzha (Il'movia Pad', Transbaikalia). Bonn,

Le premier, 2003 - Le premier Empire des Steppes. Actes sud,

Miniaev, Sakharovskaia, 2006 - S.S. Miniaev, L.M. Sakharovskaia. Investigation of a Xiongnu Royal Complex in the Tsaraam Valley. The Silk Road 4/1,

Миняев, Сахаровская, 2007 - С.С.Миняев, Л.М.Сахаровская. Элитный комплекс захоронений сюнну в пади Царам. // Российская археология. № 1, М.,

Miniaev, Sakharovskaia, 2007 - S.S. Miniaev, L.M. Sakharovskaia. Investigation of a Xiongnu Royal Complex in the Tsaraam Valley Part 2: The Inventory of Barrow No. 7 and the Chronology of the Site. The Silk Road 5/1,

Наваан, 1999 - Д.Наваан. Хүннүгийн өв соёл.

УБ.,

Николаев, 2023 – Н.Н.Николаев. Погребальные сооружения могильника Оргойтон. “Поющие стрелы Маодуня” Хунну от неизвестности до империи. Санкт-Петербург,

孔祥星, 劉一曼 2003 - 孔祥星, 劉一曼 (安京淑譯). 中國古代銅鏡. 주류성,

Полосьмак и др, 2008 - Н.В. Полосьмак, Е.С. Богданов, Д.Цэвээндорж, Н.Эрдэнэ-Очир. Изучение погребального сооружения кургана 20 в Ноин-уле (Монголия). Археология, этнография и антропология Евразии. 2 (34),

Руденко, 1962 - С.И.Руденко. Культура Хуннов и Ноинулские курганы. М-Л.,

史記, 김원중, 2005 - 사마천. 史記. 김원중 역. 을유문화사,

Сүхбаатар, 1980 - Г.Сүхбаатар. Монголчуудын эртний өвөг. УБ.,

Ханулсын бичиг 2016–Вангу. Ханулсын бичиг, Хүннүгийн шастир (орчуулсан Б.Батжаргал). УБ.,

漢書 外國傳 譯註 (上) 2009 – 譯註 中國 正史 外國傳 2, 漢書 外國傳 譯註 (上). 동북아역사재단,

Хатанбаатар нар, 2023 – Д.Хатанбаатар, Ж.Мөнхдэлгэр, Р.Төгссайхан, Б.Очир, С.Болормаа, Д.Түмэн, М.Эрдэнэ, Э.Мижиддорж, Д.Мандах, Д.Баярсайхан, Н.Санжмятав, Б.Цэндбаяр, Г.Ариунцэцэг, У.Өлзийдулам. Ямаан усны Хүннүгийн язгууртны булшны судалгаа-I. УБ.,

黃曉芬, 2006 - 한대의 무덤과 그 제사의 기원. 학연문화사,

Umehara, 1960 - Sueji Umehara. Studies of Noin-Ula finds in North Mongolia. The Toyobunko. Tokyo,

Цэвээндорж нар, 2008 - Д.Цэвээндорж, Н.В. Полосьмак, Н.Батболд, Н.Эрдэнэ-Очир, М.Цэнгэл. Ноён уулын Хүннүгийн язгууртны 20-р булшны судалгаа. Археологийн судлал, Боть 24, дэвтэр 20, УБ.,

신용민, 2000 - 漢代 木槨墓 研究. 학연문화사,

Chistyakova, 2009 - A.N.Chistyakova. Chinese inscription on the lacquer cup from Noyon ula mound 20 (Mongolia). Archaeology Ethnology and Anthropology of Eurasia. 37/3, Novosibirsk, <https://doi.org/10.1016/j.aecae.2009.11.006>

Эрдэнэбаатар нар, 2015 - Д.Эрдэнэбаатар, Т.Идэрхангай, Э.Мижиддорж, С.Оргилбаяр,

Н.Батболд, Б.Галбадрах, А.Маратхаан. Балгасан тал дахь Гол мод-2-ын Хүннүгийн язгууртны булшны судалгаа. УБ.,

Эрдэнэбаатар нар, 2021 - Д.Эрдэнэбаатар, Т.Идэрхангай, Э.Мижиддорж, Б.Галбадрах, Ж.Эрдэнэ, Б.Өнөрбаяр, А.Маратхаан, Б.Батчимэг, Б.Мягмарсүрэн, Жоу Лиган, Лан Ванли, Лю Бин, Рен Шао, Ни Фен. Хүннүгийн язгууртны булшны судалгаа (Балгасан тал дахь Гол мод-2). УБ.,

Эрэгзэн, 2009 - 에렉첸(Г.Эрэгзэн). 몽골 흥노 무덤 연구(Монголын Хүннү булшны судалгаа). 서울대학교 박사학위논문(Сөүлийн Үндэсний их сургуулийн докторын диссертаци),

Эрэгзэн нар, 2011, 2015 – Г.Эрэгзэн, П.Алдармөнх. Дуурлиг нарсны Хүннү булш I, II. ШУА-ийн Археологийн хүрээлэн, Монголын Үндэсний музей, Солонгосын Үндэсний музей. Сөүл.

Эрэгзэн нар, 2018 – Г.Эрэгзэн, У Сэй Ён, Ким Жин гён, П.Алдармөнх, С.Энхболд, Ким Сан мин, Хуанбо Чан со. Гуа довын Хүннүгийн дурсгал. УБ.,

Эрэгзэн нар, 2020 – Г.Эрэгзэн, С.Энхболд, П.Алдармөнх, Чу Санги, У Жэ жин, Им Дун жэ, Ан Жэ пил. Чихэртийн зоо ба Баянцагааны дурсгал. УБ.,

Эрэгзэн нар, 2022 – Г.Эрэгзэн, С.Энхболд, Д.Мандах, Э.Амарболд. “Бэлхийн амны Хүннүгийн язгууртны булшны археологийн судалгаа” төслийн тайлан. АХГБС, УБ.,

Эрэгзэн нар, 2022 – Г.Эрэгзэн, П.Алдармөнх, С.Энхболд, Д.Мандах, Гу Ен бёл, Паг Хаг сү, Ну Жи хён, У Хён дог, И На гён, Жан Жүн вон, Ча Жон а, Ха Тэ рун, Хун Жун ха, Хван жин Ёон. Дуурлиг нарсны Хүннү булш-III. Язгууртны 160-р булшны дагуул булшны судалгаа. УБ.,



Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.

See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.